

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норовцэрэн	Дугаар	L107
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сумын	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Суварганы хийд	Сүм хийдийн дугаар	ХЭМР 063
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймгийг Мөрөн сумын Суварганы хийд

-Суварган хийд хэр олон ламтай байсан юм бол?

Багцаагаар 20,30 лам байсан байхаа.

-Жаргалтхааны энэ хавьцаа нэг хийд тодрохгүй байна?

Жаргалтхааны наана чинь Гичгэний хийд гэж байсан.

Тэрнээс өөр хийд дуулсан уу?

Өлзийтөөс баруун хойш байсан байхаа.

-Нэрийг нь санаж байна уу?

Үгүй. Бид нарын үед хийд энэ тэр байгаагүй болохоор.

-Номтын хийд гэж хаана байсан юм бол? Шорвогоос хойш?

Тэрийг мэдэхгүй байна.

Манай суварган хийд энэ жагсаалтанд алга?

Суварган хийдэд чинь чадалтай лам нар байсан гэж байгаа. Их сайхан газар байдаг байсан. Мөргөдөг тийм соронзтой модтой байсан. Хөгшин модыг нь тайраад хаячихсан.Залуу мод ургаж байгаа гэл үү?

-Жаргалтхааны наад талд Гичгиний хурлаас өөр хурал байсан юм уу ? Жаргалтхаан Мөрөн хоёрын зааг дээр Замбилан хийд гэж байсан байх юм?

Жаргалтхааны тэнд хийд байсан гэвэл Гончиг гуай л нарийн мэдэж магадгүй.